

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ дүрмийн зорилго нь Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, удирдлага зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, мэргэжлийн боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн оролцоог хангаж, нийгмийн түншлэлийн өргөжүүлэхэд чиглэсэн орон тооны бус байгууллага юм.
- 1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.
 - 1.3.1. Хууль дээдлэх
 - 1.3.2. Ил тод нээлттэй байдлыг хангах
 - 1.3.3. Тэгш эрхийг хангах
 - 1.3.4. Асуудлыг олон талаас нь харж, зөвшилцлийг эрхэмлэх
 - 1.3.5. Хариуцлага хүлээх чадвартай байх
 - 1.3.6. Төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- 1.4. Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.5. Өвөрхангай аймаг дахь мэргэжлийн боловсролын салбар зөвлөл нь МБСургалтын тухай хууль, МБСҮЗөвлөлийн дүрэм, бусад хууль эрх зүйн акт, Мэргэжлийн боловсрол сургалтын Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн дүрмийг баримтлан үйл ажиллагаагаа зохицуулна.

Хоёр. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн бүрэн эрх

- 2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагыг тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх хүрээнд дараах бүрэн эрх эдэлнэ.
 - 2.1.1. Орон нутгийн хэмжээний Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулахад оролцож хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангахад идэвхтэй оролцох
 - 2.1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тогтоомжийн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжиж байгаа байдалд үнэлэлт өгч, мэдээлэл, илтгэл, зөвлөмж, чиглэл гарган бодлого боловсруулагчдад хүргэх
 - 2.1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогч талуудыг холбох үүрэг гүйцэтгэж, тэдний хүлээх үүрэг хариуцлага, хамтын ажиллагааны чиглэл, арга хэлбэрийг тодорхойлох, уялдуулан зохицуулах
 - 2.1.4. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагад суралцуулах мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд үндэслэн, элсэлтийн хяналтын тоог тогтоох талаар бодлогын зөвлөмж гаргах
 - 2.1.5. Орон нутгийн захиргаа, ажил олгогч, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, төрийн захиргааны дэргэдэх сургалтын байгууллага, хөдөлмөрийн албад, аж ахуй нэгж, мэргэжлийн холбоодоос мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдсон зах зээлийн эрэлтийн судалгаа гаргуулан авч санал боловсруулах
 - 2.1.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах ажил олгогч,

ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуй нэгж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага зэрэг сонирхогч этгээд нэгдэн нийгмийн түншлэлийг бүрдүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт нийгмийн түншлэлийн хоёр ба гурван талт харилцааг зохицуулах

- 2.1.7. Улсын болон орон нутгийн хэмжээнд мөрдөх ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын стандартыг орон нутгийн түвшинд мөрдөх асуудлыг хэлэлцэж дүгнэлт, санал гаргах
- 2.1.8. Орон нутгийнхаа Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох саналыг санхүү, боловсрол, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
- 2.1.9. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн холбоод, сум багийн МБС-тай холбоотой асуудлаар тайлан, мэдээллийг хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргах
- 2.1.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, нөхцлийг сайжруулах, багш, удирдах ажилтныг чадавхжуулах, сургаж хөгжүүлэх асуудлаар санал, зөвлөмж гаргах
- 2.1.11. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах чиглэлээр холбогдох нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, гишүүд дэмжигчидтэйгээ хамтран ажиллах, мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр хийгдэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хариуцуулан гүйцэтгэх талаар нутгийн захиргаа болон хурлын байгууллагатай ажиллах
- 2.1.12. Монгол Улс нэгдэн орсон Мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтэд нутгийнхаа түвшинд үнэлгээ өгч, судалж, зөвлөмж, санал гаргах
- 2.1.13. МБСҮЗөвлөлөөс тогтоосон Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагын цалингийн сангаас Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд оруулах хандивыг орон нутгийнхаа түвшинд бүрдүүлэх асуудлаар санал боловсруулан холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх
- 2.1.14. Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, ажиллагчдын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон улсын байгууллагаас Монгол улсад олгож буй зээл тусламжийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрт, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авч, судалгаа дүгнэлт хийх, тэдгээрийн үр нөлөөг нь сайжруулах талаар санал, зөвлөмж гаргах
- 2.1.15. Гаргасан шийдвэр, зөвлөмжийнхөө хэрэгжилтэнд хяналт тавих
- 2.1.16. Хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрээр олгогдсон бусад эрх эдлэх

Гурав. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

- 3.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь төрийн байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоодийн төлөөллөөс бүрдэнэ.
- 3.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөл нь төрийн байгууллагын 5 ажил олгогч, хувийн хэвшлийн 4 нийт 9 гишүүнтэй байна.
- 3.3. Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн дарга, гишүүд зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн тохиолдолд дараагийн эрх бүхий этгээд мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн дарга, гишүүний үүргийг залгамжлан гүйцэтгэнэ.

- 3.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 3.5. Хуралдааныг салбар зөвлөлийн дарга удирдах бөгөөд даргын эзгүйд нарийн бичгийн дарга хуралдааныг удирдан зохион байгуулна.
- 3.6. Зөвлөлийн хуралдааныг жилд 3-4 удаа зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.
- 3.7. Орон нутгийн салбар зөвлөлийн хуралд 5-аас доошгүй гишүүд оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 3.8. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны хэлэлцэх асуудлыг боловсруулан салбар зөвлөлийн даргаар батлуулж, хэлэлцэх асуудлын танилцуулга, тооцоо, судалгаа болон шаардлагатай бусад материалыг хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ. Хүргүүлэхдээ орон нутгийн салбар зөвлөлийн группэд байршуулж болно.
- 3.9. Орон нутгийн салбар зөвлөлийн хуралдааны үеэр тэмдэглэл хөтлөх бөгөөд хурлын шийдвэрийг тэмдэглэлд тусгасан байна. Гишүүд санал нийлээгүй асуудлыг мөн тусгаж өгнө.
- 3.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн хуралдаан нь хэлэлцсэн асуудлаараа зөвлөмж, тогтоол, дүгнэлт гаргах бөгөөд тогтоолд Мэргэжлийн боловсрол сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тухайн асуудлыг хариуцаж байгаа албан тушаалтан оруулж танилцуулна.
- 3.12. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж буй асуудлаар санал зөрсөн тохиолдолд асуудлыг зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй. Энэ тохиолдолд санал оруулсан тал үндэслэл, тооцоог хянаж үзсэний үндсэн дээр асуудлыг зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлнэ.

Дөрөв. Мэргэжлийн боловсрол, сургалтын орон нутгийн салбар зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Мэргэжлийн боловсрол сургалтын чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаанд үнэлэлт өгч, гарсан үнэлгээний дүгнэлтэнд үндэслэн бүх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах санал боловсруулан Засаг даргын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх
- 4.2. Мэргэжлийн боловсрол сургалтанд оролцогч талуудын ойлголт хандлагыг дээшлүүлэх, нэн ялангуяа сум, багийн удирдлага, ард иргэд хувийн хэвшлийнхэнд чиглэсэн арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, Мэргэжлийн боловсрол сургалтыг сурталчлан таниулах ажлыг аймаг орон нутгийн хэмжээнд өргөн зохион байгуулах
- 4.3. Аймгийн хэмжээнд нэн түрүүнд сургаж бэлтгэх шаардлагатай мэргэжлийн эрэлт, хэрэгцээг гурваас доошгүй жилээр тооцон гаргах, шаардлагатай мэргэжил эзэмшүүлэхээр ерөнхий боловсролын сургууль төгсөгч болон мэргэжлийн сургалтанд хамруулах ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоо, балансыг гаргах
- 4.4. Мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаатай холбоотой сонирхогч талууд бүгд ашиглах боломжтой вебсайт нээн ажиллуулах, Мэргэжлийн боловсрол сургалтын талаар мэдээллийн нэгдсэн санг байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

- 4.5. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих хүрээний үйл ажиллагааг зохион байгуулж буй сум, баг, Засаг даргын тамгын газрын болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж шилдэг туршлагын аймаг, орон нутгийнхаа хэмжээнд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллах
- 4.6. Аймгийн хэмжээний мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, дүгнэлт гаргах
- 4.7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- 4.8. Аймгийн хэмжээний мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт мэргэжлийн түвшний үндэсний тогтолцоог хэрэгжүүлж байгаа талаарх мэдээлэл, илтгэл зөвлөмж гаргах, чиглэл өгөх
- 4.9. Улсын хэмжээнд мөрдөх ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын стандартыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх дүгнэлт гаргах
- 4.10. Аймгийн хэмжээний мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт хяналт тавих
- 4.11. Мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцийн биелэлтийг аймгийн хэмжээнд судлан гаргаж, дүгнэлт санал гаргах
- 4.12. МБСҮЗ, төр засгийн гаргасан шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих
- 4.13. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах
- 4.14. Аймгийн хэмжээний мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх
- 4.15. Аймагт үйл ажиллагаагаа явуулж буй төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах, байгуулах, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах талаар дүгнэлт гаргах
- 4.16. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг судлах сурталчлах энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
- 4.17. Аймгийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын хүний нөөц, суралцагчдын нийгмийн хамгаалалын бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх
- 4.18. Сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшлийг нэвтрүүлэх арга хэмжээг аймгийн түвшинд зохион байгуулах